

## Хэсэг 1

### **“Сорилт бэрхшээлд эцэс гэж үгүй: Эрс өөрчлөлтийн цаг үед эдийн засаг, улс төр, байгаль орчны асуудалд анхаарах нь”**

Жонатан С. Аддлетон

*Редакторын тайлбар: Элчин сайд Жонатан Аддлетон Монголын хүрээлэн буй орчин, эдийн засгийн өсөлт болон улс төрийн хөгжлийн хоорондын харилцан хамаарал, голлох асуудлуудыг өргөн хүрээнд авч үзсэн байна. Тэрбээр өнөөгийн Монголын хөгжилд уул уурхайн оруулж буй хувь нэмэр болон эдийн засгийн хурдацтай хөгжлийн талаар өгүүлэхдээ уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэйгээр байгаль орчинд учирч буй сөрөг үр дагавар, бэлчээрийн мал аж ахуйтай холбоотой бэлчээрийн даац хэтрэлт, усны хомсдлын асуудал зэргийг давхар хөндсөн төдийгүй уул уурхай дангаараа байгаль орчинд үзүүлж байгаа сөрөг үр дагаварыг ч мөн дурдсан байна.*

*Доктор Ж.Аддлетон Монголын улс төрийн хөгжлийн ахиц болон түүнд учирч буй саад бэрхшээлийн талаар дурдахын сацуу улс төр, эдийн засгийн амжилттай шилжилтэнд хурдацтай өөрчлөлт, эдийн засгийн хөгжил дарамт учруулж байгаа тухай дурдсан байна. Тэрээр энэ нь жам ёсны, үргэлжлэх үйл явц болохыг онцлон тэмдэглэжээ.*

*Элчин сайд, доктор Ж.Аддлетон энэ хурлын идэвхтэй оролцогчдын нэг байсан бөгөөд тэрээр хурлыг нээн үг хэлж, илтгэлээ бүрэн эхээр нь танилцуулсан юм. Түүний илтгэлийг АНУ-ын Засгийн газрын зөвшөөрлөөр бүрэн эхээс нь товчлон хүргэж байна.*

---

“Уул уурхай, улс төрийн эдийн засаг ба эдийн засгийн тогтвортой байдал” гэсэн нилээд өргөн хүрээтэй, том сэдвээр товч эргэцүүлэл хийх боломж олгосонд баярлалаа.

Үнэндээ энэхүү салбар хуралдааны сэдэв өргөн хүрээтэй байгаад, ялангуяа нилээд богино хугацааны дотор санаа бодлоо эвлүүлж бичих ёстой болсон энэ завшаанд би талархалтай байна. Олон сэдвийг хөндөж, нэг удаа хэд хэдэн өөр чиглэлээр ярьж болох өргөн хүрээтэй салбар хуралдааны илтгэл тавих боломжийг энэхүү сэдэв олгож байна.

Зарим асуудал дээр арай илүү тогтож ярих үүднээс энэхүү өргөн хүрээтэй сэдвийн хүрээнд тавих илтгэлээ би “Сорил бэрхшээлд эцэс гэж үгүй: Эрс өөрчлөлтийн цаг үед эдийн засаг, улс төр, байгаль орчны асуудалд анхаарах нь” гэж нэрлэлээ.

Олон улсын туршлагаас харахад эрдэс баялгийн нөөц ихтэй орнууд асар их сорил бэрхшээлтэй тулгардаг. Зарим орнууд эдгээр бэрхшээлийг даван туулах “ээрэг” үлгэр жишээ үзүүлж байхад зарим нь “сөрөг” жишээ харуулах нь ч бий. Монголын бодлого тогтоогчид Норвеги, Ботсвана, Чили зэрэг харьцангуй “амжилтын түүх”-тэй орнуудын туршлагатай аль хэдийн тодорхой хэмжээгээр танилцсан байгаа. Канад, Австрали зэрэг томоохон орнууд ч бас Монголын хувьд нэн хэрэгтэй байж болох “сургамж”-ийг харуулдаг.

Эдгээр харьцангуй эерэг жишээ бүгд л боловсрол, сайн засаглалын аль алинд хөрөнгө оруулахын чухлыг, авилгын асуудлыг хөндөх хэрэгтэйг, ашигт малтмалын зах зээлийн үнэ зайлшгүй буурах үе тохиохыг урьдчилан харж, өндөр байгаа үед нь мөнгөний хуримтлал үүсгэх ёстойг, дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийхийн чухлыг, мөн зөвхөн ашигт малтмалд тулгуурласан нэг хэмжээст эдийн засгаас зайлсхийхийн тулд олон төрөлт эдийн засгийг дэмжих хэрэгтэйг онцолсон байдаг.

Түүнээс гадна ашигт малтмалаар баялаг орнууд нь ирээдүйгээ тодорхойлох улс төр, эдийн засгийн шийдвэрийн аль алиныг хийдэг учраас ил тод байдал, хяналт шалгалтын систем маш хэрэгтэй байдгийг олон улсын туршлага харуулдаг.

Ашигт малтмалын их нөөцтэй эдийн засаг, түүнээс гэнэт

орж ирж болох ашгийг удирдах бэрхшээлтэй тулгарах үед Монголын хувьд бичиг үсэгт тайлагдсан хувь өндөр, нийгмийн бүх хэсэгт биш гэхэд ихэнх салбарт эмэгтэйчүүдийн оролцоо харьцангуй их, олон улсын туршлага Монголд хамаатай гэдгийг хүлээн зөвшөөрч байгаа зэрэг нь давуу тал болох юм.

Онолын хувьд, парламентын үр ашигтай систем нь “хяналт, шалгалт”-тай холбоотой асуудлыг хөндөхөд тустай бөгөөд зөвхөн их мөнгөтэй, эсвэл нөлөө бүхий хүмүүсийн биш, харин Монголын олон нийтийн дуу хоолойг сонсгох форум болох ёстой. Энэ шалтгааны улмаас энэхүү бага хурлын үеэр явагдах парламентын үйл ажиллагааны тухай, УИХ-ын гишүүн болно гэдэг юу болох, сонгуулийн систем бодит практикт хэрхэн ажилладаг тухай хэлэлцүүлгүүд маш чухал бөгөөд хэрэгтэй юм.

Монголд байгаа олон улсын байгууллагуудын нэг зорилго бол олон улсын туршлагыг Монголд танилцуулахад орших бөгөөд харин ирээдүйнхээ тухай шийдвэрийг Монголчууд өөрсдөө гаргах ёстой гэдгийг хүлээн зөвшөөрч байдаг.

Монголын хөгжил дэх байгаль орчны асуудлын тухайд гэвэл энэ асуудлыг шийдвэрлэхэд тустай байж болох хэд хэдэн саналыг энд хэлэх гэсэн юм.

Нэгдүгээрт, уул уурхайтай холбоотой байгаль орчны асуудлууд мэдээж санаа зовоож буй хэдий ч энэ нь цорын ганц шалтгаан биш юм. Уул уурхайгаас бүр ангид дэлхийн уур амьсгалын өөрчлөлт ч маш их нөлөө үзүүлж болзошгүй байна. Уур амьсгалын өөрчлөлт байхгүй байлаа ч гэсэн Монголын тал нутагт бэлчээрлэж байгаа малын тоо толгой улам нэмэгдэж байгаа нь байгаль орчинд урт хугацаандаа уул уурхайн үзүүлэх нөлөөтэй адил хэмжээний нөлөө үзүүлж байж болох юм.

Хоёрдугаарт, Монгол оронд бэлчээрийг хадгалж хамгаалж, тогтвортой байлгахын тулд хэдий хэмжээний малтай байх ёстойг би багцаалж хэлж зүрхлэхгүй. Гэхдээ

байгаль орчинд бэлчээрийн менежментийн үзүүлэх нөлөө уул уурхайн салбарын үзүүлэх нөлөөний дайтай чухлаар тавигдах асуудал гэдгийг би баттай хэлэх байна.

Гуравдугаарт, жижиг, том төслийн алинд ч миний бодлоор усны асуудал, ялангуяа Монголын хувьд зөвхөн уул уурхайн салбарт төдийгүй бусад салбарт ч маш том асуудал болон тавигдаж байна.

Өөрөөр хэлбэл, Монголын хөх тэнгэр үнэхээр мөнх байж болно. Харин Монголын хөх нуурууд, хөх гол, горхинууд, бүр газрын хэвлий дэх хөх усан сан ч мөнх байна гэсэн үг биш юм.

Үлдсэн хэдэн минутад би хэлэх үгээ яагаад “Сорил бэрхшээлд эцэс гэж үгүй” гэж нэрлэсэн тухайгаа тайлбарлая. Өнгөрсөн хорин жилийн хугацаанд Монголд юу болсон тухай янз бүрийн шүүмжлэлийг эргэн харахад зарим ажиглагчид Монгол улс “бодлогын диваажин”, эсвэл “нийгмийн нирваан” мэтээр дүрслэгдэж болох тийм төлөв байдалд хүрэх нэг цэг байгаа, хэрэв тодорхой багц зарчмуудыг хэрэгжүүлбэл энэ нь хэзээ нэгэн цагт тодорхой, төгс төгөлдөр бөгөөд эцсийн цэгт зайлшгүй хүргэнэ хэмээн төсөөлдөг юм шиг надад санагддаг.

Мэдээж бодит амьдрал дээр төгс төгөлдөр багц бодлогыг эрж олно гэдэг эцэс төгсгөлгүй, ихэнхдээ учир замбараагүй урт аян байдаг. Үнэндээ асар их хөдөлмөрлөж, хатуу бэрхийг туулан нэг хэсэг зорилгоо биелүүлэхэд дахиад цоо шинэ сорил бэрхшээлүүд зайлшгүй гарч ирдэг.

Монголын хувьд, магадгүй Монголтой ижил нөхцөлд байгаа ямар ч орны хувьд амжилт олох тусам илүү их бэрхшээлтэй нүүр тулдаг болов уу гэсэн бодол надад улам ихээр төрөх боллоо. Өнөө үеийн Монголчууд яах аргагүй маш өргөн хүрээтэй сорил бэрхшээлүүдтэй тулгарч байгаагийн дотор Монгол Улс олон талаараа, олон учир шалтгааны үүднээс илүү нарийн төвөгтэй, ээдрээтэй газар болж байгаа нь бодит үнэн билээ. Нэг шалтгаан нь мэдээж хэрэг нэмэгдэл баялгийг даган гарч ирэх нэмэгдэл хувь оролцоо байна. Гэхдээ түүнээс

гадна хувь хүмүүс, иргэдэд сонголт хийх ганц, хоёрхон биш, маш олон боломжууд улам бүр нээгдэж байгаагийн улмаас Монгол илүү ээдрээтэй газар болж байгаа нь бодит баримт юм. Эдгээр сонголтууд заримдаа өөр хоорондоо зөрчилдөх нь гайхмаар зүйл биш бөгөөд энэ нь сайн засаглал ба үр ашигтай шүүх эрх мэдлийн аль аль нь чухал болохыг цохон тэмдэглэж байгаа юм.

Илүү өргөн хүрээнд гэвэл хувь хүмүүс болоод Монголын нийгмийн хувьд шийдвэр гаргах үйл явц бол эцэс төгсгөлгүй зүйл юм. Нэг салбарт олсон амжилт шинэ шинэ сорилт бэрхшээлд төдийгүй зайлшгүй хийх ёстой илүү төвөгтэй, шинэ шийдвэрүүдэд хөтлөн аваачих нь бий.

Монголын иргэд, хувь хүмүүс, эсвэл төр засаг нь нэг тодорхой багц асуудал, бэрхшээлийг даван тууллаа гэж итгэх бүрт шинэ бэрхшээлүүд гарч ирдэг нь тодорхой түвшинд Монголыг ацан шалаанд оруулж буй асуудал юм.

Монголд элэгтэй гадаадынхан буюу жуулчин, эрдэмтэн судлаач, бизнес эрхлэгч, тусламжийн болон над шиг дипломат ажилтан хэн ч бай заримдаа хэрэг болохуйц зөвлөгөө өгч магадгүй. Гэхдээ энд амьдарч буй Монголчуудын хувьд мэдээж энэ түүх хэд хэдэн үеийг хамарч, одоо гаргасан шийдвэр хойч үеийнхэнд нь нөлөө үзүүлэх учраас илүү урт бөгөөд ээдрээтэй байна. Энэ өнцгөөс харвал, энэ хурлын гурван сэдэв болох “эдийн засгийн тэмүүлэл, улс төрийн хөгжил, соёлын төрх” өмнөхөөс илүү чухал болж байна гэдгийг хэлмээр байна. Үнэндээ энэ гурван сэдвийн алиныг нь ч тус тусад нь “хөндөх” буюу “шийдвэрлэх” боломжгүй юм. Энэ гурав харин ч нягт холбоотой бөгөөд аль нэгэнд нь гарсан өөрчлөлт болоод бэрхшээлүүд нөгөө хоёртоо заавал нөлөөлж, тодорхойлж байдаг.

Монгол улс асар их сорилт бэрхшээл болон эрс өөрчлөлтийн аль алинаар нь тэмдэглэгдэх цаг үеийг туулан урагшилж буй энэ үед иймэрхүү төрлийн дүн шинжилгээ, эргэцүүлэл улс орон доторх хэлэлцүүлгийг улам баяжуулах байх гэж итгэж байна.